



"ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ БАТЛАХ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН 1999 ОНЫ 27 ДУГААР ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт буурч, айл өрхийн амьжиргаа, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл үүсч манай улсын инфляци 2022 онд 14.8 хувьтай гарч, өндөр хувиар агшсан байна.

Сүүлийн саруудад худалдаа, үйлчилгээ хэвийн горимд үе шаттай шилжин эдийн засагт сэргэлт ажиглагдаж, гадаад, дотоод худалдаа, үйлчилгээ нээгдэн эдийн засаг аажмаар сэргэх нөхцөл, хандлага ажиглагдсан боловч Оросын Холбооны Улс болон Украин Улсын хооронд зэвсэгт мөргөлдөөн эхэлснээр дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өсч манай улсад нийлүүлэгддэг газрын тосны бүтээгдэхүүн АИ-92 автобензин, дизель түлшний үнэ 2022 оны 3 дугаар сараас хойш тасралтгүй өсөн өндөр үнээр тогтворжоод байна.

Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах чиглэлээр дэлхийн улс орнууд татвар, төсөв, мөнгөний бодлогын хэрэгслээр харилцан адилгүй арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагаас гадна энэхүү гадаад үнийн шок удаан үргэлжлэх төлөвтэй байгааг харгалзан бүтээгдэхүүний үнэ, хангамжид анхаарсан бодлого гол төлөв хэрэгжүүлж байна.

Дэлхийн нийтийн хэмжээнд цар тахлын цаашдын төлөв байдал болон Оросын Холбооны Улс болон Украин Улсын зэвсэгт мөргөлдөөний үргэлжлэх хугацаа, олон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл тодорхой бус, нөхцөл байдал түргэн хугацаанд эрс өөрчлөгдөж байгаа энэ цаг үед ард иргэдийн амьдралд хамгийн том нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн хомсдол үүсэх, үнэ өсөхөөс сэргийлэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг онцгой журмаар зохицуулж шийдвэрлэх зайлшгүй шаардлага тулгараад байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт Монгол Улсын Засгийн газар нь “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ” гэж тус тус заасанд үндэслэн Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй ард иргэдийн өргөн хэрэглээний газрын тосны бүтээгдэхүүн АИ-92 автобензинийн үнийн өсөлтийг бууруулах, тогтворжуулах зорилгоор "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" УИХ-ын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг боловсруулна.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл 5 зүйлтэй байх бөгөөд 1, 2 дугаар зүйлээр Монгол Улсын эдийн засаг, нийгэм, инфляцыг тодорхойлогч хэрэглээний сагсанд томоохон хувь эзэлдэг газрын тосны бүтээгдэхүүн АИ-92 автобензинийн гаалийн албан татварын хувь хэмжээг 0-5 хувиар тогтоох эрхийг Засгийн газарт олгох, 3 дугаар зүйлээр газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний гаалийн албан татварыг 0-5 хувиар гэж хязгаар заасан байгааг 5 хувь гэж заах, 4 дүгээр зүйлээр хууль дагаж мөрдөх хугацааг заах юм.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дэлхийн нийтийн хэмжээнд цар тахлын цаашдын төлөв байдал болон Оросын Холбооны Улс болон Украин Улсын зэвсэгт мөргөлдөөний үргэлжлэх хугацаа, олон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл тодорхой бус, нөхцөл байдал түргэн хугацаанд эрс өөрчлөгдөж байгаа энэ цаг үед ард иргэдийн амьдралд хамгийн том нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүнийн хангамж нийлүүлэлтийн хомсдол үүсэх, үнэ өсөхөөс сэргийлж, тогтворжуулах, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах эерэг үр дагавар бий болно.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулах бөгөөд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.